

**МЭДЭЭЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ХЭЛТСИЙН ОРОН ЗАЙН МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМИЙН
УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН А.УЯНГЫН
2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН
ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС**

Байгууллагын нэр: Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар
Нэгжийн нэр: Мэдээлэл, технологийн хэлтэс

1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо	Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал	Нийлбэр оноо	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3	4	5
	Оноо	60 хүртэл	10 хүртэл	70 хүртэл	
Зорилт 1. Газрын кадастрын мэдээллийн сангийн нэгдсэн системээс авах үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй хүргэх					
1.	Арга хэмжээ 1.1. Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийг байгууллагуудын мэдээллийн сантай холбож, дундын мэдээллийн сан байгуулах	55	10	65	
2.	Арга хэмжээ 1.2. Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийн хөгжүүлэлтийн ажлыг гүйцэтгүүлэх, хяналт тавьж ажиллах	50	10	60	
3.	Арга хэмжээ 1.3. Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийн өгөгдлийн санг бие даасан байдалд шилжүүлэх ажил	50	10	60	
Зорилт 2. Блокчейнд суурилсан Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим систем, орон зайн өгөгдлийн Геоортал цахим системийн хөгжүүлэлт					
1.	Арга хэмжээ 2.1. Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн Геоортал цахим системд нэмэлт хөгжүүлэлт хийх, хэрэглээнд нэвтрүүлэх	50	10	60	
2.	Арга хэмжээ 2.2. Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн Геоортал цахим системийн хэвийн үйл ажиллагааг хангах	60	10	70	
3.	Арга хэмжээ 2.3. Байгууллагын орон зайн суурь мэдээллийг тогтмол шинэчлэх боломжийг	60	10	70	

	бүрдүүлэх, шаардлагатай өгөгдлийг бусад системүүдээс гарган авах, солилцох ажлыг зохион байгуулах				
4.	Арга хэмжээ 2.4. Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн Геоортал цахим системээс төрийн болон бусад байгууллагуудыг орон зайн суурь мэдээллээр ханган ажиллах	60	10	70	
5.	Арга хэмжээ 2.5. Салбарын бүтээгдэхүүн, үйлчилгээг иргэн, хуулийн этгээдэд хүргэх ухаалаг төхөөрөмж /киоск/-ийн тоо, чанарыг нэмэгдүүлэх, хэрэглээнд нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах	55	10	65	
6.	Арга хэмжээ 2.6. Байгууллагын дата төв, цахим системүүдэд мэдээллийн аюулгүй байдлын аудит, эрдлийн үнэлгээ хийлгэх ажлыг зохион байгуулах	50	10	60	
7.	Арга хэмжээ 2.7. Үндэсний орон зайн өгөгдлийн дэд бүтцийн Геоортал цахим системийн өгөгдлийн санг шинэчлэн зохион байгуулах, хэрэглэгчийн програм хангамжийн хөгжүүлэлт ажил	60	10	70	
Зорилт 3. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ					
1.	Арга хэмжээ 3.1. Удирдлагаас болон хурлаас өгөгдсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх, тайлагнах	60	10	70	
2.	Арга хэмжээ 3.2. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллаж, тайланг тушаалд заасан хугацаанд холбогдох мэргэжилтэнд хүргүүлэх	60	10	70	
3.	Арга хэмжээ 3.3. Тогтоол шийдвэрийн биелэлт гаргах	60	10	70	
4.	Арга хэмжээ 3.4. Хугацаатай албан бичиг, өргөдөл гомдол шийдвэрлэх, хяналт тавьж ажиллах	60	10	70	

5.	Арга хэмжээ 3.5. Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу архивын баримт бүрдүүлэх, хавтаслах, байгууллагын архивт хүлээлгэн өгөх	60	10	70	
Дундаж оноо:				66,6	

2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний биелэлтийн хувь	Нийт (15 хүртэл оноогоор)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3	4
1.	Арга хэмжээ 1. Газрын харилцааны салбарт ашиглагдаж болохуйц технологийн шийдлийн талаар судалж, импакт фактор бүхий олон улсын сэтгүүлд өгүүлэл хэвлүүлэх.		10	
2.	Арга хэмжээ 2. Орон зайн өгөгдөл, мэдээлэл технологийн дэвшилтэт технологийг газрын салбарт ашиглах боломжийн талаар олон улсын богино хугацааны сургалтад хамрагдах		10	
Дундаж оноо			10	

3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)

Д/д	Үзүүлэлт	Нэгжийн даргын үнэлгээ (0-15 оноо)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3
1.	Хандлага, ёс зүй	7	
2.	Дүн шинжилгээ хийх	7	
3.	Асуудал шийдвэрлэх	7	
4.	Хариуцлагатай байдал	7	
5.	Ажлын цаг ашиглалт	7	
Дундаж оноо		2	

4. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)

Д/д	Үзүүлэлт	Хамт олны үнэлгээ (0-8 оноо)
	1	2
1.	Хандлага, ёс зүй	8
2.	Багаар ажиллах	8
3.	Харилцаа	8
Дундаж оноо		8

5. Гүйцэтгэлийн үнэлгээ

Д/д	Үнэлгээний үзүүлэлт	Үзүүлэлт тус бүрийн оноо
1.	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт (Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт орно.)	66,6
2.	Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт	10
3.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)	7
4.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)	8
5.	Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт (Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)	
Нийт оноо = (Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо (Нэгжийн даргын болон хамт олны үнэлгээ)) - Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо + Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо		91,6

Үнэлгээ өгсөн:

Мэдээлэл, технологийн
хэлтсийн дарга

Нэгжийн дарга

..... П.НЯМДАВАА
2025.06.05 (огноо)

Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:

Орон зайн мэдээллийн системийн
удирдлага, зохион байгуулалт
хариуцсан ахлах мэргэжилтэн

Төрийн жинхэнэ албан хаагч:

..... А. УЯНГА
2025.06.05 (огноо)

Үнэлгээг хянасан:

Үнэлгээний багийг төлөөлж:

Төрийн захиргаа
удирдлагын газрын дарга

Үнэлгээний багийн нарийн
бичгийн дарга

..... Б.ЭНХБОЛД
2025.06.16 (огноо)

..... М.Сүмъяабаатар
2025.06.16 (огноо)

Үнэлгээг баталгаажуулсан:

ГЗБГЗЗЕГ-ын дарга

Төсвийн шууд захирагч

..... А.ЭНХМАНЛАЙ
2025.06.27 (огноо)



ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙГ ХАНГУУЛАХ
ЯВЦЫН ЯРИЛЦЛАГЫН ТЭМДЭГЛЭЛ

Албан хаагчийн овог, нэр: А. Уянга

Ярилцлага хийсэн огноо: 2025 оны 06 сарын 03 өдөр

Ярилцлагын хэлбэр: 1.Биечлэн 2.Утсаар 3.Цахим хэлбэрээр


Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хангалтгүй буюу эрчимжүүлэх шаардлагатай арга хэмжээний тухай	Нэгжийн даргаас өгсөн үүрэг даалгавар
Зорилт 2.10. “Төрийн үйлчилгээний ил тод байдлыг хангаж, цахим үйлчилгээг хөгжүүлэх замаар салбарын хэмжээнд цахим шилжилт хийх үйл ажиллагааг дэмжих”			
1.	Арга хэмжээ 2.10.1.13. Байгууллагын орон зайн суурь мэдээллийг тогтмол шинэчлэх боломжийг бүрдүүлэх, шаардлагатай өгөгдлийг бусад системүүдээс гарган авах, солилцох ажлыг зохион байгуулах	ГЗБГЗЗЕГ-ын 10 цахим систем, түүний мэдээллийн санд агуулагдах өгөгдлийн мета мэдээллийг ЦХИХХЯ-ны Төрийн мета өгөгдлийн нэгдсэн сан (https://metadata.nso.mn)-д оруулах ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Орон зайн 18 суурь өгөгдлийн сангийн 233 дэд давхаргад өгөгдлийн сангийн өнөөгийн байдлыг үнэлэх, өгөгдлийн бүрдэл болон бүрэн бүтэн байдал, баяжилтыг шалгах ажлыг хийж гүйцэтгэсэн. Үүнд үндэслэн орон зайн өгөгдлийг бүрдүүлэгч байгууллагуудыг тодорхойлох, байгууллага хоорондын хамтын ажиллагааг сайжруулах, өгөгдөл давхардлаас сэргийлэх, батлагдсан стандартын дагуу хүснэгтэн мэдээллээр суурь өгөгдлийн санг үүсгэх, баяжуулах ажлыг зохион байгуулахаар ажиллаж байна.	1. Бусад төрийн байгууллагат орон зайн өгөгдөл солилцох боломжийг бүрдүүлэх; 2. ҮОЗӨДБ-ийн эрхзүйн орчныг сайжруулах, орон зайн өгөгдөл бүрдүүлэгч байгууллагуудын уялдаа, холбоог сайжруулах, хүний нөөцийг чадавхижуулах төслийг боловсруулах

	ҮОЗӨДБ-ийн эрхзүйн орчныг сайжруулах, орон зайн өгөгдөл бүрдүүлэгч байгууллагуудын уялдаа, холбоог сайжруулах, хүний нөөцийг чадавхижуулах зорилгоор Ашиа Айр Сурвей (Asia Air Survey) ХХК-ын төлөөлүүдтэй нийт 3 удаагийн хурал зохион байгуулж, Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллага (ЖАЙКА)-т “Монгол Улсад Үндэсний орон зайн өгөгдлийн дэд бүтцийн бодлогын орчныг сайжруулах, орон зайн өгөгдөлд суурилсан цахим шилжилтийг дэмжих төсөл”-ийн техникийн хамтын ажиллагааны хүсэлтийг англи, монгол хэлээр боловсруулж ажилласан.	
--	--	--

ЯРИЛЦЛАГА ХИЙСЭН:

Мэдээлэл, технологийн хэлтсийн дарга
(Албан тушаал)


..... /П.Нямдаваа/
(Нэр, гарын үсэг)

МЭДЭЭЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ХЭЛТСИЙН ОРОН ЗАЙН МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ ХАРИУЦСАН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН А.УЯНГЫН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХАГАС ЖИЛИЙН БИЕЛЭЛТ

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин		Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэт-гэлийн хувь
				Эхний хагас жил	Сүүлийн хагас жил		
	1	2	3	4	5	6	7
Зорилт 1. Газрын кадастрын мэдээллийн сангийн нэгдсэн системээс авах үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй хүргэх							
1.	Арга хэмжээ 1.1. Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийг байгууллагуудын мэдээллийн сантай холбож, дундын мэдээллийн сан байгуулах	Дундын мэдээллийн сан-1	Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийг улсын хэмжээнд нэвтрүүлсэн.	Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийн өгөгдлийн санг шинэчлэх системийн шийдлийг гүйцэтгэгчтэй хамтран боловсруулсан байна.	Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийг бусад байгууллагуудын мэдээллийн сантай холбож дундын мэдээллийн санг хэрэглээнд нэвтрүүлсэн байна.	Тус ажлын хүрээнд 2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 2024/325 дугаартай “Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийг байгууллагуудын мэдээллийн сантай холбож, дундын мэдээллийн санг байгуулах үйлчилгээ үзүүлэх” гэрээ байгуулагдсан. Үүний дагуу хийгдсэн ажлууд. Үүнд: Сүлжээ: ТЕГ-ын Мэдээллийн аюулгүй байдлын газарт хүсэлт хүргүүлж Төрийн нэгдсэн сүлжээгээр дамжуулан сүлжээний гарцын хаяг Татварын Ерөнхий Газар, Улсын бүртгэлийн ерөнхий газруудын хаягийг нэмүүлэн, хаягуудыг сүлжээний төхөөрөмжид тохируулсан. Программ хангамж: Тус Дундын мэдээллийн сантай холбох ажлын хүрээнд системийн архитектур шийдлийг тодорхойлон, хөгжүүлэлтийг хийсэн. Техник хангамж:	

						2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр Дундын мэдээллийн сангийн серверийн үйлдлийн системийг (OS) Ubuntu 22.04.1, Процессор 32, Санах ой 64, Хатуу дискийг 1 ТБ-аар тохируулан гүйцэтгэгчид хүлээлгэн өгсөн. Сервис үйлчилгээ: Тус ажлын хүрээнд Татварын Ерөнхий Газар, Цахим хөгжил, инноваци, харилцаа холбооны яаманд тус тус http://10.10.224.72:8000/api/v1/dynamic/22 буюу Газрын нэгж талбараар солбицол дуудах сервисийг гаргасан.	
2.	Арга хэмжээ 1.2. Газрын нэгдмэл сангийн удирдлагын цахим системийн хөгжүүлэлтийн ажлыг гүйцэтгүүлэх, хяналт тавьж ажиллах	Систем хөгжүүлсэн байдал	Газрын кадастр, Хаяг, Газрын нэгдмэл сан, Хот байгуулалтын кадастрын системд хөгжүүлэлт хийгдэж, үйл ажиллагаанд нэвтрүүлсэн байна.	Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийн хөгжүүлэлтийн ажлын даалгаврыг боловсруулж, батлуулан цахим системд нэмэлт хөгжүүлэлт хийх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулсан байна.	Газрын кадастр, Хаяг, Газрын нэгдмэл сан, Хот байгуулалтын кадастрын системд хөгжүүлэлт хийгдэж, үйл ажиллагаанд нэвтрүүлсэн байна.	Тус ажлын хүрээнд ГЗБГЗЗЕГ-ын даргын 2025 оны 02 дугаар сарын 17-ны А/70 тушаалаар Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим систем, Хот байгуулалтын кадастрын цахим систем, И-газар цахим системийн хөгжүүлэлт хийх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үүрэг бүхий Үнэлгээний хороо байгуулагдсан. Газрын кадастрын систем, Газрын нэгдмэл сангийн систем, Хот байгуулалтын кадастрын систем, И-Газар цахим системийн хөгжүүлэлт хийх хоёр багц ажлын даалгаврыг боловсруулж, 2025 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн	

						АД/2025-09 (Багц-1), АД/2025-10 (Багц-2) дугаартайгаар тус тус батлуулсан. Гүйцэтгэчийг сонгон шалгаруулахаар худалдан авах ажиллагааны цахим системээр 2025 оны 02 дугаар сарын 26-ны өдөр зарлаж 2025 оны 03 дугаар сарын 20-ны өдөр тендерийг нээж үнэлгээний хороо оролцогчдын тендерийг хянан үзэж үнэлэх үйл ажиллагааг зохион байгуулсан ба гүйцэтгэгчээр “Эрхэт инноваци” ХХК шалгаран ажиллаж байна. 2025 оны 03 дугаар сарын 01-нээс 06 дугаар сарын 01-ний хооронд “Эрхэт инноваци” ХХК, “Софт мастер” ХХК компаниудад сүлжээ, эх код, өгөгдлийн сан, техник хангамж зэрэг хөгжүүлэлтийн ажил гүйцэтгэхэд шаардлагатай орчныг бүрдүүлэх нийт 28 ажил, ГНСУНС-д үүссэн нөхцөл байдлыг арилгах зэрэг 12 ажил гүйцэтгээд байна.
				Цахим системийн өгөгдлийн санг шинэчлэн зохион байгуулах гүйцэтгэчийг сонгон	Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийн өгөгдлийн санг шинэчлэн зохион байгуулж бие даасан байдалд	“ГНСУНС-ын өгөгдлийн санг шинэчлэн зохион байгуулах, бие даасан байдалд шилжүүлэх” ажлын даалгаврыг боловсруулан 2025 оны 02 дугаар сарын 18-ны өдөр батлуулсан. Төрийн худалдан авах ажиллагааны газарт тус ажлыг зарлах эрхийг
				-		

				шалгаруулсан байна.	шилжүүлсэн ажлыг шалгаж, хүлээн авсан байна.	шилжүүлэх тухай хүсэлтээ 2025 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн 1/764 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. Үнэлгээний хороо байгуулагдахаар хүлээгдэж байна. Мөн дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд: 1. Системийн архитектур шийдэл: ГНСУНС-ийн одоогийн нөхцөл байдал дээр дүн шинжилгээ хийж архитектур шийдлийн хувилбаруудыг гаргаж орон зайн өгөгдөл, дэд бүтцийн газар хүлээлгэн өгсөн. 2. Техник хангамжийн ажлын даалгавар: Техник хангамжийн зохион байгуулалт, шинэчилсэн өгөгдлийн сангийн зохион байгуулалтын шийдлийн зургийг тооцоолол дээр үндэслэн гарган ажлын даалгавруудыг бэлтгэн тухайн асуудал хариуцсан албан хаагчид хүлээлгэн өгсөн. 3. Сүлжээний өргөтгөл, сайжруулалт: Системийн архитектур шийдэл, техник хангамжийн шийдлийн дагуу сүлжээний өргөтгөлийн төхөөрөмж, хурдны сайжруулалт зэргийг тооцоолон ажлын даалгаврыг боловсруулж 2025 оны 03
--	--	--	--	---------------------	--	--

							дугаар сарын 27-ны өдөр батлуулсан ба гүйцэтгэчийг сонгон шалгаруулах тендерийг зарласан.	
Зорилт 2. Блокчейнд суурилсан Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим систем, орон зайн өгөгдлийн Геопортал								
4.	Арга хэмжээ 2.1. Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн Геопортал цахим системд нэмэлт хийх, хөгжүүлэлт хэрэглээнд нэвтрүүлэх	Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн Геопортал цахим системд хийсэн нэмэлт хөгжүүлэлтийн тоо	Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн Геопортал цахим системийн 2.0 системийн хувилбарыг 2024 онд хэрэглээнд нэвтрүүлсэн.	Геопортал цахим системийн хөгжүүлэлтийг гүйцэтгэгчтэй хамтран болон бие даан хийж гүйцэтгэсэн байна.	Геопортал цахим системийн хөгжүүлэлтийг гүйцэтгэгчтэй хамтран болон бие даан хийж гүйцэтгэн хэрэглээнд нэвтрүүлсэн байна.	Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн Геопортал цахим системийн хөгжүүлэлт хийх ажлын даалгаврыг 2025 оны 02 дугаар сарын 27-ны өдөр боловсруулан, батлуулсан. 2025 оны А/19 дүгээр тушаалаар батлагдсан ГЗБГЗЗБГ-ын 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө дагуу тендерийг 2025 оны 02 дугаар сарын 28-ны өдөр зарласан. Үнэлгээний хороо тендерийг хянан үзэж, шаардлага хангасан оролцогч материал ирүүлээгүй тул дахин зарлахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.		
5.	Арга хэмжээ 2.2. Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн Геопортал цахим системийн хэвийн ажиллагааг хангах	Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн Геопортал цахим системд хийсэн нэмэлт хөгжүүлэлтийн тоо түүний хэвийн үйл ажиллагаа	Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн Геопортал цахим системийн 2.0 системийн хувилбарыг 2024 онд хэрэглээнд нэвтрүүлсэн.	Геопортал цахим системд шаардлагатай тохируулга, хөгжүүлэлтийг хийж гүйцэтгэн хэвийн үйл ажиллагааг хангасан байна.	Геопортал цахим системд шаардлагатай тохируулга, хөгжүүлэлтийг хийж гүйцэтгэн хэвийн үйл ажиллагааг хангасан байна.	Тус ажлын хүрээнд Геопортал цахим системийн хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор 2025 оны 01 дүгээр сарын 05-наас 2 дугаар сарын 01-ний өдрүүдэд 192.168.10.93, 192.168.10.237 өгөгдлийн сангийн доголдол арилгах тэнцвэржүүлэлт хийж ажилласан. И-Монгол Академи УТУГ-тай сервис солилцооны хүрээнд Хил заагийн мэдээлэл болох		

							Нийслэл, Аймаг, Сум, дүүргийн хилийн цэсийн мэдээллүүдийг бодит агшинд солилцох сервисийг гарган хүлээлгэн өгсөн. Геопортал цахим системээр дамжуулан төрийн болон бусад байгууллагуудыг орон зайн суурь мэдээллээр ханган ажиллах зорилгоор Эдийн засаг, хөгжлийн яамд шаардлагатай орон зайн өгөгдөл, мэдээллийг ArcGIS сервер ашиглан (www.gisserver.gazar.gov.mn:6443/arcgis) үйлчилгээ үзүүлэхээр бэлтгэл ажлыг ханган ажилласан. Онцгой байдлын ерөнхий газрын Гамшгийн үеийн удирдлагын нэгдсэн системийг шаардлагатай орон зайн өгөгдлөөр хангах ажлын хүрээнд 2025.06.03-нд ГЗБГЗЗЕГ-т хамтарсан хурал зохион байгуулж Гамшгийн үеийн удирдлагын нэгдсэн системд шаардлагатай орон зайн 16 төрлийн өгөгдөл, мэдээллийг дамжуулах, солилцох боломжийг судалж, GeoJSON, WMS хэлбэрээр орон зайн өгөгдлөөр хангахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.	
7.	Арга хэмжээ 2.3. Байгууллагын орон зайн суурь	Орон өгөгдлийн дэд бүтцийн	- Орон зайн суурь өгөгдлийн	Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн	Орон өгөгдлийн дэд бүтцийн	ГЗБГЗЗЕГ-ын 10 цахим систем, түүний мэдээллийн санд агуулагдах өгөгдлийн		

мэдээллийг тогтмол шинэчлэх боломжийг бүрдүүлэх, шаардлагатай өгөгдлийг бусад системүүдээс гарган авах, солилцох ажлыг зохион байгуулах.	Геоортал цахим системээс орон зайн өгөгдөл, мэдээлэл авч ашиглаж буй цахим системийн тоо	техникийн үзүүлэлтийн MNS 6925 1-18:2021 стандартыг батлуулсан. - 2022 онд ISO 19131 Өгөгдөл техникийн үзүүлэлт стандартыг батлуулсан - Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн Геоортал цахим системийн 2.0 хувилбарыг 2024 онд хэрэглээнд нэвтрүүлсэн.	Геоортал цахим систем болон байгууллагын бусад цахим системүүд хооронд харилцан өгөгдөл, мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлсэн байна.	Геоортал цахим системээр дамжуулан стандартын дагуу бүрдүүлэгдсэн орон зайн суурь өгөгдлөөр бусад системүүдийг хэвийн хангаж ажилласан байна.	мета мэдээллийг ЦХИХХЯ-ны Төрийн мета өгөгдлийн нэгдсэн сан (https://metadata.nso.mn)-д оруулах ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Орон зайн 18 суурь өгөгдлийн сангийн 233 дэд давхаргад өгөгдлийн сангийн өнөөгийн байдлыг үнэлэх, өгөгдлийн бүрдэл болон бүрэн бүтэн байдал, баяжилтыг шалгах ажлыг хийж гүйцэтгэсэн. Үүнд үндэслэн орон зайн өгөгдлийг бүрдүүлэгч байгууллагуудыг тодорхойлох, байгууллага хоорондын хамтын ажиллагааг сайжруулах, өгөгдөл давхардлаас сэргийлэх, батлагдсан стандартын дагуу хүснэгтэн мэдээллээр суурь өгөгдлийн санг үүсгэх, баяжуулах ажлыг зохион байгуулахаар ажиллаж байна. ҮОЗӨДБ-ийн эрхзүйн орчныг сайжруулах, орон зайн өгөгдөл бүрдүүлэгч байгууллагуудын уялдаа, холбоог сайжруулах, хүний нөөцийг чадавхижуулах зорилгоор Ашиа Айр Сурвей (Asia Air Survey) ХХК-ын төлөөлүүдтэй нийт 3 удаагийн хурал зохион байгуулж, Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллага (ЖАЙКА)-т “Монгол Улсад
--	--	--	--	---	---

						Үндэсний орон зайн өгөгдлийн дэд бүтцийн бодлогын орчныг сайжруулах, орон зайн өгөгдөлд суурилсан цахим шилжилтийг дэмжих төсөл"-ийн техникийн хамтын ажиллагааны хүсэлтийг англи, монгол хэлээр боловсруулж ажилласан.	
8.	Арга хэмжээ 2.4. Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн Геопортал цахим системээс төрийн бусад байгууллагуудыг орон зайн суурь мэдээллээр ханган ажиллах	Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн Геопортал цахим системээс орон зайн өгөгдөл, мэдээлэл авч ашиглаж буй төрийн болон бусад байгууллагуудын тоо	Хамтын ажиллагааны санамж бичгийн хүрээнд 30 байгууллагын цахим системийг орон зайн суурь өгөгдөл, мэдээллээр хангаж байна.	Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн Геопортал цахим систем болон төрийн бусад байгууллагуудын цахим системүүд хооронд харилцан өгөгдөл, мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлсэн байна.	Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн Геопортал цахим систем болон төрийн бусад байгууллагуудын цахим системүүд хооронд харилцан өгөгдөл, мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлсэн байна.	Засгийн газрын 2025 оны 76 дугаар тогтоолоор газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим систем болон үндэсний орон зайн өгөгдлийн дэд бүтцийн Геопортал системд суурилан Хөгжлийн бодлого төлөвлөлтийн мэдээллийн санг байгуулахаар батлагдсан. Тус ажлын хүрээнд Эдийн засаг, хөгжлийн яамд шаардлагатай орон зайн өгөгдөл, мэдээллийг ArcGIS сервер ашиглан (www.gisserver.gazar.gov.mn:6443/arcgis) үйлчилгээ үзүүлэхээр бэлтгэл ажлыг хангасан. Эдийн засаг, хөгжлийн яамтай хамтран ажиллах санал боловсруулж хүргүүлсэн. Онцгой байдлын ерөнхий газрын Гамшгийн үеийн удирдлагын нэгдсэн системийг шаардлагатай орон зайн өгөгдлөөр хангах ажлын хүрээнд 2025 оны 06 дугаар сарын 03-ны өдөр ГЗБГЗЗЕГ-т хамтарсан хурал зохион	

						байгуулсан. Тус ажлын хүрээнд Гамшгийн үеийн удирдлагын нэгдсэн системд шаардлагатай орон зайн 16 суурь мэдээллийг дамжуулах, солилцох боломжийг судалж, цаашид хамтарсан ажлын хэсэг байгуулахаар ажиллаж байна.	
9.	Арга хэмжээ 2.5. Салбарын бүтээгдэхүүн, иргэн, үйлчилгээг этгээдэд хүргэх хуулийн ухаалаг төхөөрөмж /киоск/-ийн хангах, үйл ажиллагааг чанарыг үйлчилгээний сайжруулах ажлын хүрээнд киоск төхөөрөмжтэй холбоотой тулгамдаж буй асуудал, цаашид боловсронгуй болгоход тусгах хөгжүүлэлтийн саналыг 21 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар болон нийслэл, дүүргийн Газар зохион байгуулалтын албадаас авч нэгтгэн киоск төхөөрөмжийг хөгжүүлэгч “Смарт Дата” ХХК, “Эрхэт Инноваци” ХХК-д 2025 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн 2/907, 2/908 болон 2025 оны 05 сарын 09-ны өдрийн 2/1615, 2/1616 тоот албан бичгүүдээр саналыг хүргүүлж ажилласан. Мөн Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий	Хэрэглээнд нэвтрүүлсэн ухаалаг төхөөрөмж /киоск/-ийн тоо, түүний хөгжүүлэлт	Улсын хэмжээнд нийт 27 ухаалаг төхөөрөмж ашиглагдаж байна	Гүйцэтгэгчтэй хамтран ухаалаг төхөөрөмж /киоск/-ийн хөгжүүлэлтийг хийх, салбар байгууллагуудтай хамтран тоог нэмэгдүүлж хэрэглээнд гаргасан байна.	Гүйцэтгэгчтэй хамтран ухаалаг төхөөрөмж /киоск/-ийн хөгжүүлэлтийг хийх, салбар байгууллагуудтай хамтран тоог нэмэгдүүлж хэрэглээнд гаргасан байна.	Газрын харилцааны бүтээгдэхүүн, үйлчилгээг иргэн, хуулийн этгээдэд хүргэх киоск төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагааг хангах, үйлчилгээний чанарыг сайжруулах ажлын хүрээнд киоск төхөөрөмжтэй холбоотой тулгамдаж буй асуудал, цаашид боловсронгуй болгоход тусгах хөгжүүлэлтийн саналыг 21 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар болон нийслэл, дүүргийн Газар зохион байгуулалтын албадаас авч нэгтгэн киоск төхөөрөмжийг хөгжүүлэгч “Смарт Дата” ХХК, “Эрхэт Инноваци” ХХК-д 2025 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн 2/907, 2/908 болон 2025 оны 05 сарын 09-ны өдрийн 2/1615, 2/1616 тоот албан бичгүүдээр саналыг хүргүүлж ажилласан. Мөн Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий	

						газрын цахим хуудас (www.gazag.gov.mn)-т киоск төхөөрөмжөөс авах боломжит үйлчилгээнүүд, үнэ тариф болон байршлийг иргэн, хуулийн этгээдэд хүртээмжтэй байхаар байршуулсан. Засгийн газрын 2024 оны 173 дугаар тогтоолоор батлагдсан "Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим систем болон орон зайн өгөгдлийн мэдээллийн сангаас үзүүлэх үйлчилгээ, лавлагаа, мэдээлэл авах үйлчилгээний хөлсний хэмжээ"-н дагуу киоск төхөөрөмжид холбогдох хөгжүүлэлтийг хийж хэрэглээнд нэвтрүүлсэн. Гадаад улсад оршин суугаа Монгол Улсын иргэдэд газрын харилцааны бүтээгдэхүүн, үйлчилгээг хүргэх зорилгоор гадаад улсад байгаа Монгол улсын элчид сайдын яамд, дипломат төлөөлөгчийн газарт байршуулсан киоск төхөөрөмжөөр дамжуулан хүргэх боломжийг судалж, сүлжээ, аюулгүй байдал, бусад холбогдох үйл ажиллагаанд зөвлөмж хүсч Тагнуулын ерөнхий газарт 2025.05.27-ны өдрийн 1/1893 тоот албан бичиг хүргүүлсэн.
10.	Арга хэмжээ 2.6.	Мэдээллийн аюулгүй	Монгол улсын Кибер	Байгууллагын дата төв, цахим	Байгууллагын дата төв, цахим	Тус газрын даргын 2025 оны А/120 дугаар "Байгууллагын

	Байгууллагын дата төв, цахим системүүдэд мэдээллийн аюулгүй байдлын аудит, эрсдлийн үнэлгээ хийлгэх ажлыг зохион байгуулах	байдлын аудит, эрдлийн үнэлгээний дүгнэлт	аюулгүй байдлын тухай хуулийн 17.1.7 дахь хэсэгт заасныг үндэслэн 2024 онд байгууллагын зарим цахим системүүдэд мэдээллийн аюулгүй байдлын аудит, эрдлийн үнэлгээг хийлгэсэн.	системүүдэд мэдээллийн аюулгүй байдлын аудит, эрдлийн үнэлгээ хийлгэн, дүгнэлтийн холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна	системүүдэд мэдээллийн аюулгүй байдлын аудит, эрдлийн үнэлгээ хийлгэн, дүгнэлтийн холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна	дата төвд мэдээллийн аюулгүй байдлын аудит” ажлын гүйцэтгэчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог байгуулж худалдан авах ажиллагааг амжилттай зохион байгуулсан. 2025 оны 05 сарын 01-ний өдөр “Систем центр” ХХК-д гэрээ байгуулах эрх олгох мэдэгдлийг хүргүүлсэн. Мөн 2025 оны 05 сарын 21-ний өдөр Тагнуулын ерөнхий газарт 1/1767 дугаар бичгээр “Систем центр” ХХК-д кибер аюулгүй байдлыг эрсдэлийн үнэлгээ хийлгэхээр зөвшөөрөл хүсэх тухай албан бичгийг хүргүүлэн ажиллаж байна. Тус газарт Тагнуулын ерөнхий газраас Мэдээллийн аюулгүй байдлын аудит хийсэн бөгөөд холбогдох материал, шаардлагатай баримт зэргийг тухай бүр танилцуулж хамтран ажилласан.ЫЫЫЫ	
11.	Арга хэмжээ 2.7. Үндэсний орон зайн өгөгдлийн дэд бүтцийн Геопортал цахим системийн санг өгөгдлийн зохион шинэчлэн байгуулах, хэрэглэгчийн програм хангамжийн хөгжүүлэлт ажил	Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн Геопортал цахим системийн хэвийн үйл ажиллагаа	Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн Геопортал цахим системийг хэрэглээнд нэвтрүүлсэн.	Геопортал цахим системийн арчилгаа, нэмэлт хөгжүүлэлтийн явцад хяналт тавьж, гэрээний хэрэгжилтийг шалгаж хүлээж авсан байна.	Геопортал цахим системийн арчилгаа, нэмэлт хөгжүүлэлтийн явцад хяналт тавьж, гэрээний хэрэгжилтийг шалгаж хүлээж авсан байна.	Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн Геопортал цахим системийн хөгжүүлэлт хийх ажлын даалгаврыг 2025 оны 02 дугаар сарын 27-ны өдөр боловсруулан, батлуулсан. 2025 оны А/19 дүгээр тушаалаар батлагдсан ГЗБГЗЗЕГ-ын 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө дагуу тендерийг	

							2025 оны 02 дугаар сарын 28-ны өдөр зарласан. Үнэлгээний хороо тендерийг хянан үзэж, шаардлага хангасан оролцогч материал ирүүлээгүй тул дахин зарлахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.
Зорилт 3. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ							
12.	Арга хэмжээ 3.1. Удирдлагаас болон хурлаас өгөгдсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх, тайлагнах	Үүрэг даалгаврын тоо	-	Өгөгдсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлсэн байна.	Өгөгдсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлсэн байна.	Тус газрын даргын дэргэдэх зөвлөлийн хурал, удирдах ажилтны шуурхай болон цаг үеийн холбогдолтой үүрэг даалгаврын биелэлтийг ханган тухай бүр нь тайлагнан ажилласан. Тухайлбал, - Газрын бодлого, төлөвлөлтийг оновчтой хийхэд орон зайн өгөгдлөөр дэмжлэг үзүүлэх, олон улсын сайн туршлагыг Монгол улсад нутагшуулах зорилгоор Бүгд Найрамдах Сингапур Улсын Газрын Агентлаг /Singapore Land Authority/-тай орон зайн мэдээлэл, газрын кадастрын салбарт хамтран ажиллах санамж бичгийн төслийг боловсруулж, цахим уулзалт зохион байгуулсан. Санамж бичгийн төсөл нь ГЗБГЗЗЕГ-аас хянагдаж, Сингапур улсын Газрын Агентлаг руу англи хэл рүү орчуулан цахим шуудангаар хүргүүлсэн бөгөөд тус газарт хянагдах шатанд явж байна.	

							- БНХАУ-ын Жэжян аймгийн Дэчин хотод байрлах НҮБ-ын Дэлхийн Орон Зайн Мэдээлэл, Инновацийн төвтэй газар зохион байгуулалт болон орон зайн өгөгдлийн чиглэлээр хамтран ажиллах санамж бичгийн төсөл боловсруулан ажилласан.	
13.	Арга хэмжээ 3.2. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллаж, тайланг тушаалд заасан хугацаанд холбогдох мэргэжилтэнд хүргүүлэх	Тушаалд заасан хугацаа	-	Тухай бүр ажлын ажлын хэсэгт ажиллах, хэрэгжилтийг тайлагнасан байна.	Тухай бүр ажлын хэсэгт ажиллах, хэрэгжилтийг тайлагнасан байна.	Тухай бүр ажлын хэсэгт ажиллах, хэрэгжилтийг тайлагнасан байна.	Тайлант хугацаанд ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажиллаагүй байна.	
14.	Арга хэмжээ 3.3. Тогтоол шийдвэрийн биелэлт гаргах	Тогтоол, шийдвэрийн тоо	-	Холбогдогдох тогтоол шийдвэрийн биелэлтийг цаг хугацаанд нь тайлагнасан байна.	Холбогдогдох тогтоол шийдвэрийн биелэлтийг цаг хугацаанд нь тайлагнасан байна.	Холбогдох тогтоол, шийдвэр, төлөвлөгөөний биелэлтийг тухай бүр тайлагнан ажилласан.		
15.	Арга хэмжээ 3.4. Хугацаатай албан бичиг, өргөдөл гомдол шийдвэрлэх, хяналт тавьж ажиллах	Шийдвэрлэсэн албан бичиг, өргөдөл, гомдлын тоо	-	Нэгжид ирсэн хугацаатай албан бичиг, өргөдөл гомдлыг заасан хугацаанд нь шийдвэрлэсэн байна.	Нэгжид ирсэн хугацаатай албан бичиг, өргөдөл гомдлыг заасан хугацаанд нь шийдвэрлэсэн байна.	2025 оны эхний хагас жилд нийт 28 албан бичиг хүлээн авч, холбогдох арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан. Тухайлбал, - Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 352 дугаар тогтоолоор баталсан Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоон, үнэлгээ хийх журмын 4.1-т заасны дагуу байгууллагын нээлттэй		

						мэдээллийн ил тод байдлын үнэлгээг хийн, Хууль зүй, дотоод хэргийн яаманд 2025.01.30-ны өдрийн 1/348 тоот албан бичгээр хүргүүлэн ажилласан. - Нийслэлийн Газар зохион байгуулалтын албанаас 2025.02.20-ны өдрийн 01-09/930 тоот албан бичгээр тус газарт ирүүлсэн ArcGIS серверийн лицензийн эрхийг шилжүүлж өгөх тухай албан бичгийг 2025.02.28-ны 1/751 тоот албан бичгээр Мон Мэп ХХК-д хүргүүлсэн. Хүсэлтийн дагуу тус лицензийг ГЗБГЗЗЕГ-ын нэр дээр бүртгэж, орон зайн дэд бүтцийн Геопортал цахим системээс төрийн болон бусад байгууллагуудыг орон зайн суурь мэдээллээр ханган ажиллахад ашиглаж байна. - И-Монгол академи УТҮГ-аас 2025.04.16-ны өдрийн 01/197 тоот албан бичгээр ирүүлсэн хүсэлтийн дагуу Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (E-Mongolia)-ийн 5.0 хувилбарыг хөгжүүлж, хэрэглээнд нэвтрүүлэх ажлын хүрээнд газрын харилцааны бүтээгдэхүүн, үйлчилгээтэй холбоотой мэдээлэл, зөвлөмж, түгээмэл асуулт, хариултыг бэлтгэн хүргүүлсэн. Мөн тайлант хугацаанд 11 албан
--	--	--	--	--	--	---

							бичиг төлөвлөн, холбогдох байгууллагуудад хүргүүлэн ажилласан.	
16.	Арга хэмжээ 3.5. Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу архивын баримт бүрдүүлэх, хавтаслах, байгууллагын архивт хүлээлгэн өгөх	Архивт хүлээлгэн өгсөн баримтын тоо	-	Нэгжийн урьд онд хийсэн ажлын баримт бичгийг тайлант оны эхний улиралд багтаан байгууллагын архивт хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулсан байна.			Тайлант хугацаанд архивын баримт бичиг хүлээлгэн өгөөгүй байна.	

ХОЁР. МЭДЛЭГ, УР ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин		Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэт-гэлийн хувь
				Эхний хагас жил	Сүүлийн хагас жил		
1.	Арга хэмжээ 2.1. Газрын харилцааны салбарт ашиглагдаж болохуйц технологийн шийдлийн талаар судалж, импакт фактор бүхий олон улсын сэтгүүлд өгүүлэл хэвлүүлэх	Өгүүлэл - 1	3 -	Газрын харилцааны салбарт ашиглагдаж болохуйц технологийн шийдлийн талаар судалж, импакт фактор бүхий олон улсын сэтгүүлд өгүүлэл хэвлүүлсэн байна.	Газрын харилцааны салбарт ашиглагдаж болохуйц технологийн шийдлийн талаар судалж, импакт фактор бүхий олон улсын сэтгүүлд өгүүлэл хэвлүүлсэн байна.	6 - ХААИС, ШУА-ийн Газарзүй, Геоэкологийн хүрээлэн хамтран зохион байгуулсан Газрын харилцаа-2025 эрдэм шинжилгээний бага хуралд “Газрын бодлого дахь орон зайн өгөгдлийн үүрэг: Сингапур, Нидерланд, Монгол улсын жишээгээр” сэдэвт харьцуулсан судалгааны ажлаар илтгэл хэлэлцүүлсэн. Мөн олон улсын ISSN 3006-5666 дугаартай Газрын харилцаа	7

						сэтгүүлд тус судалгааны ажлыг хэвлүүлсэн болно. - 2025 оны 1 сард Импакт фактор 3.2 үнэлгээ бүхий олон нийтэд нээлттэй (open access) Лэнд сэтгүүлд Улаанбаатар хотын хотыг дахин хөгжүүлэх төслүүд дэх олон нийтийн оролцооны ялгаатай байдал (Divergence in Public Participation in Urban Redevelopment in Ulaanbaatar) судалгаа нь тэнцсэн бөгөөд 4 сард шаардлагатай засвар хийгдэж, дахин хүсэлт гаргасан бөгөөд хяналтын шатанд явж байна.				
2.	Арга хэмжээ 2.2. Орон зайн өгөгдөл, мэдээлэл технологийн дэвшилтэт технологийг газрын салбарт ашиглах боломжийн талаар олон улсын богино хугацааны сургалтад хамрагдах	Сертификат	-	Сургалтад хамрагдсан байна.	Сургалтад хамрагдсан байна.	Орон зайн өгөгдөл, мэдээлэл технологийн дэвшилтэт технологийг газрын салбарт ашиглах боломжийн талаар олон улсын богино хугацааны сургалтад хамрагдахаар судалж байгаа бөгөөд хамрагдах өргөдөл боловсруулан ажиллаж байна.				

ХЯНАН БАТАЛГААЖУУЛСАН:

Мэдээлэл, технологийн хэлтсийн дарга


.....

.....

П.Нямдаваа 2025.06.05

БОЛОВСРУУЛСАН:

Орон зайн мэдээллийн системийн удирдлага, зохион байгуулалт хариуцсан ахлах мэргэжилтэн

А.Уянга 2025.06.05